

ҮНИЙН САНАЛ УРИЛГЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:	Видео архивын материал бэлтгэх
Тендер шалгаруулалтын №:	CS08
Тендер шалгаруулалтын арга:	Харьцуулалт – зөвлөх бус үйлчилгээ
Төслийн нэр:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл
Санхүүжүүлэгч:	Дэлхийн банкны зээл, Төсөл № P173779, 100 хувь санхүүжүүлнэ
Урилгын огноо:	2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: Видео архивын материал бэлтгэх
Тендер шалгаруулалтын №: CS08
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт – зөвлөх бус үйлчилгээ
Төслийн нэр: “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл
Санхүүжүүлэгч: Дэлхийн банкны зээл, Төсөл № P173779, 100 хувь санхүүжүүлнэ.
Урилгын огноо: 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

1. Дэлхийн банкны санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд энэ гэрээг санхүүжүүлнэ.
2. Сонирхсон этгээд нь piu@ehp.mn имэйлээр хандан Монгол хэл дээр үйлдсэн Үнийн саналын урилгын баримт бичгийг имэйлээр хүлээн авч болно.
3. Сонирхсон этгээдэд Үнийн саналын урилгын баримт бичгийг үнэ төлбөргүй илгээнэ.
4. Энэ харьцуулалтын аргаар явуулах тендер шалгаруулалтыг Дэлхийн банкны “Procurement Regulations for IPF Borrowers” November 2020 edition (“Procurement Regulations”) журмын дагуу хэрэгжүүлнэ.
5. Сонирхсон этгээд нь зөвхөн нэг үнийн санал ирүүлнэ. Хувилбарт үнэтэй үнийн саналаас захиалагч татгалзана.
6. Таны үнийн санал нь принтерээр хэвлэгдсэн, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгатай байна. Үнийн саналын маягтад гарын үсэг зурж, тамга дараагүй бол үнэлгээнд харгалзахгүй.
7. Тендерийн баталгаа ирүүлэх шаардлагагүй. Гүйцэтгэлийн баталгаа шаардлагагүй.
8. ҮНЭ: “Ажил үйлчилгээний тодорхойлололт” бүлэгт заасан бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай үнийг ирүүлнэ. Үнийг төгрөгөөр илэрхийлнэ. Үнийг гэрээний хэрэгжилтийн хугацаанд тохируулахгүй. Үнэд дараах татвараас бусад татварыг тооцож оруулна: захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ.
9. ҮНИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ: Техникийн шаардлагад нийцсэн хэмээн үнэлэгдсэн үнийн саналуудын үнийг хооронд нь харьцуулна. Хэрэв үнийн санал нь энэ Үнийн саналын урилгын баримт бичгийн нөхцөл болзол, үзүүлэлт, тодрхойлолтыг биелүүлээгүй, эсвэл тэдгээрийг материаллагаар зөрчсөн бол, үнийн саналыг шаардлагад нийцээгүй гэж тооцно. Захиалагч нь зөвхөн шаардлагад нийцсэн үнийн саналыг дараагийн шатны үнэлгээнд хамруулна. Дараагийн шатанд захиалагч нь арифметик алдааг залруулна.

Танай компани нь:

- (1) Үнийн саналын маягтыг доор заасан маягтын дагуу бэлтгэж ирүүлнэ.
- (2) Сүүлийн 4 жилийн (2020, 2021, 2022, 2023) хугацаанд доод тал нь 2 гэрээг үндсэн гүйцэтгэгчийн хувьд гүйцэтгэж, дуусгасан байх. Эдгээр гэрээний бүтээгдэхүүний үргэлжлэх хугацаа нь энэ урилгын гэрээний бүтээгдэхүүний хугацаатай ойролцоо буюу 60 орчим минут байх, нийт гэрээний үнийн нийлбэр дүн нь 120 сая төгрөгөөс багагүй байх, найруулга, тавилт нь мөн энэ гэрээнийхтэй ойролцоо байх. Үнийн саналын хамт өмнөх гэрээ, хүлээн авсан акт, уг гэрээгээр гүйцэтгэсэн видео материалыг DVD format-аар CD-нд хуулж, CD-ийг ирүүлнэ, эсхүл үнэ төлбөргүй үзэж болох вэбсайт, платформын линкийг ирүүлнэ.
- (3) Видео архивын материал бэлтгэх ажлын дарга / продюсер / найруулагч: доод тал нь 3 ижил төрлийн ажлыг энэ үүрэгтэйгээр гүйцэтгэсэн байх. Анкет, боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом, гэрчилгээ/, ажил олгогч, харилцагч байгууллагын тодорхойлолтыг ижил төрлийн ажилд гүйцэтгэсэн үүргийн тайлбар, нотлох баримтын хамт ирүүлнэ.
- (4) Видео архивын материалын агуулгын зохиолч: доод тал нь 3 ижил төрлийн ажлыг энэ үүрэгтэйгээр гүйцэтгэсэн байх. Анкет, боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом, гэрчилгээ/, ажил олгогч, харилцагч байгууллагын тодорхойлолтыг ижил төрлийн ажилд гүйцэтгэсэн үүргийн тайлбар, нотлох баримтын хамт ирүүлнэ.
- (5) Зураглаач / Эвлүүлэгч: доод тал нь 3 ижил төрлийн ажлыг энэ үүрэгтэйгээр гүйцэтгэсэн байх. Анкет, боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом, гэрчилгээ/, ажил олгогч, харилцагч байгууллагын тодорхойлолтыг ижил төрлийн ажилд гүйцэтгэсэн үүргийн тайлбар, нотлох баримтын хамт ирүүлнэ. Доод тал нь зураглаачийн бакалавр болосвролтой байх.
- (6) Гэрээний ажил гүйцэтгэх төлөвлөгөөг ирүүлнэ.
- (7) Гэрээний нөхцөл болзолыг доор заасан маягтын дагуу бэлтгэж ирүүлнэ.
- (8) Тендерт оролцогчийн өмчлөгчийн тухай мэдээллийг доор заасан маягтын дагуу бэлтгэж ирүүлнэ.
- (9) Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлнэ.

Эдгээр баримт бичгийг ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь шаардлагад нийцэхгүй бол танай үнийн саналыг шаардлагад нийцээгүйд тооцож, түүнээс татгалзана.

10. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ: Үнийн саналын урилгын баримт бичгийн шаардлагад нийцсэн, үнэлж харьцуулсаны дараа хамгийн бага үнэтэй хэмээн тооцогдсон үнийн санал ирүүлсэн этгээдэд гэрээ байгуулах эрх олгоно. Энэ этгээдтэй “Гэрээний маягт”, “Гэрээний нөхцөл, болзол”-ын маягтын дагуу гэрээ байгуулна.

11. ҮНИЙН САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА: Энэ бүлгийн 14 дүгээр зүйлд заасан өдрөөс хойш 40 хоногийн хугацаанд танай үнийн санал хүчинтэй байна.

12. Хэрэв үнийн саналын хүчинтэй хугацаанд та үнийн саналаасаа татгалзвал, эсвэл гэрээ байгуулах эрх хүлээн аваад гэрээ байгуулаагүй бол, танай компанийг тус төслийн эрх бүхий этгээдийн жагсаалтаас 2 жилийн хугацаанд хасна.

13. Таны үнийн санал нь 1 эх хувиас бүрдэх ба Үнийн саналын маягт дээр та “эх хувь” хэмээн тэмдэглэл үйлдэнэ. Та үнийн саналаа дугтуйд хийн, битүүмжилж, доорх хаягийг дугтуйн дээр бичиж, мөн хаягаар хүргүүлнэ:

Захиалагчийн хаяг: “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл, Улаанбаатар, СБД, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 11-р давхар, 1103 тоот
Утасны дугаар: 7707-7793
Цахим шуудангийн хаяг: piu@ehp.mn (энэ хаягаар ирүүлсэн үнийн саналыг хүлээн авахгүй, зөвхөн дугтуйд хийн ирүүлсэн үнийн саналыг харгалзан үзнэ)

14. Үнийн саналыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 15:00 цагаас өмнө 13 дугаар зүйлд заасан хаягаар ирүүлнэ.

15. Захиалагч аливаа үнийн саналыг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах, мөн харьцуулалтын аргаар явуулах тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, болон гэрээний эрх олгохын өмнө бүх үнийн санал, тендерээс татгалзах эрхтэй.

16. Дэлхийн банк нь Хуваарь № 1-т заасан “Авлигатай тэмцэх журам”-ыг биелүүлэхийг шаардана.

Хуваарь № А: Авлигатай тэмцэх журам Авлигатай тэмцэх журам

*(Энэхүү хавсралтад заасныг тендерийн баримт бичиг гэрээний нөхцөлд
өөрчлөхгүйгээр тусгана)*

1. Зорилго

1.1 Дэлхийн банк (цаашид Банк гэх)-ны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт бүхий худалдан авах ажиллагаанд Дэлхийн банкны Авлигатай тэмцэх журам болон энэхүү хавсралтыг мөрдөнө.

2. Шаардлага

2.1 Банк нь зээлдэгч (Банкны санхүүжилтээс үр шим хүртэгчдийг оролцуулан); тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч болон нийлүүлэгч; аливаа туслан гүйцэтгэгч, дэд зөвлөхүүд, үйлчилгээ үзүүлэгч эсхүл нийлүүлэгч, аливаа төлөөлөгч этгээд (мэдүүлсэн эсэхээс хамааран); тэдгээрийн аливаа мэргэжилтнийг Банкны санхүүжилт бүхий гэрээний худалдан авах ажиллагааны туршид сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр стандартыг ханган ажиллах, залилан мэхлэх, авлигын үйлдлээс ангид байхыг шаардана.

2.2 Энэ хүрээнд Банк нь:

- (a) Дараах нэр томъёог дор өгөгдсөн утгаар тусгасан болно. Үүнд:
- i. “Авлигын үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бус хэлбэрээр өгөхийг санал болгох, өгөх, хүлээн авах, өгөхийг шаардахыг хэлнэ;
 - ii. “Залилан мэхлэх үйлдэл” гэж аль нэг тал хүлээсэн үүргээсээ зайлсхийх эсхүл санхүүгийн болон бусад ашиг олохын тулд санаатай болон санаандгүйгээр төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийгээд дээрх зорилгоор хийгдсэн зөрүүтэй тайлбарыг хэлнэ;
 - iii. “Үгсэн хуйвалдах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг байдлаар хууль бус зорилгод хүрэхийн тулд хоёр буюу түүнээс дээш талууд хамтран далд тохиролцох ажиллагааг хэлнэ;
 - iv. “Тулган шаардах үйлдэх” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, эсхүл хэн нэгэн этгээд эсхүл түүний өмчид шууд болон шууд бусаар хохирол учруулах, хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ.
 - v. “Саад учруулах үйлдэл” гэж
 - (a) Хяналт шалгалтын нотолгооны материалыг зориудаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуун дарагдуулах, эсхүл авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, албадан шахах буюу тулган шаардах үйлдлийг тогтоохоор Банкнаас хэрэгжүүлж буй хянан шалгах ажиллагаанд зориудаар саад учруулах зорилгоор асуудлыг шалгаж байгаа мөрдөгчид худал мэдүүлэх; эсхүл тухайн хянан шалгах ажиллагаатай холбогдох мэдээллийг мэдэж буй хүн өөрийг нь илчлэхээс сэргийлж айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, мөн шалгалтын дараа гарсан шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзах зэрэг үйлдэл,
 - (b) Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журмын Хавсралт 4-ийн 2.2 е-д заасны дагуу Банкны зүгээс хянан шалгах болон аудитын эрхээ хэрэгжүүлэхэд нь ноцтой саад учруулахаар завдах үйлдлийг хэлнэ.

(b) Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсон зөвлөх хуулийн этгээд эсхүл хувь хүн, түүний аливаа ажилтан, төлөөлөгч байгууллага, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн ажилтнууд нь уг гэрээг авах зорилгоор өрсөлдөхдөө авлига, залилан мэхлэх, нууц үгсэн хуйвалдах, албадан шахах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэлд шууд болон шууд бусаар оролцсоныг Банк илрүүлсэн бол уг гэрээ байгуулах эрхийг цуцална;

(c) Холбогдох зээлийн гэрээнд заасан зөрчил арилгах арга хэмжээнээс гадна хэрэв Зээлдэгчийн төлөөлөл эсхүл зээлийн тодорхой хэсгээс хүртэгч этгээд нь тухайн гэрээний худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн явцад авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, тулган шаардах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэл гаргасныг Банк олж тогтоосон бөгөөд энэ үед Зээлдэгчийн зүгээс эдгээр зөрчил бүхий үйлдлийн талаар мэдсэн даруйдаа Банканд мэдээлээгүй, мөн Банкны шаардлагад нийцэхүйц байдлаар цаг алдалгүй засаж залруулахаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд уг худалдан авах ажиллагааг амжилтгүй гэж зарлан цуцалж болно;

(d) Банкны Авлигатай тэмцэх журмыг баримтлан, Банкнаас авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээний талаарх бодлого, журамд заасны дагуу хуулийн этгээд эсхүл хувь хүнийг тухайн заасан хугацааны туршид (i) Банкны санхүүжилт бүхий гэрээ хэрэгжүүлэх эрх авах эсхүл санхүүгийн болон бусад хэлбэрээр ашиг шим хүртэх¹; (ii) Банкны санхүүжилт бүхий гэрээ байгуулах эрх авсан эрх бүхий хуулийн этгээдийн туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр ажиллахаар нэр нь дэвших²; (iii) Банкны зээлийн аливаа хөрөнгөөс хүлээн авах эсхүл Банкны санхүүжилт бүхий төслийн бэлтгэл болон хэрэгжүүлэх шатанд оролцохыг нь хориглон, эрх бүхий бус этгээд гэж нийтэд зарлан мэдээлж болно;

(e) Банкны зээлийн санхүүжилт бүхий гэрээний болон тендерийн/санал авах баримт бичигт (i) тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч, дэд зөвлөх, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон төлөөлөгч этгээдийн хувьд бүх данс, бүртгэл тооцоо, тендер ирүүлэх болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад бичиг баримтад Банкнаас хяналт шалгалт хийх³, мөн эдгээр мэдээллийг Банкнаас томилсон аудитораар хянуулахыг зөвшөөрөх тухай заалтыг тусгасан байхыг шаардана.

¹ Эргэлзээ үүсгэхгүйн үүднээс хориг арга хэмжээ авагдсан талын гэрээ хэрэгжүүлэх эрх бүхий бус байдалд (i) урьдчилсан сонголтод оролцох, зөвлөх үйлчилгээнд сонирхлоо илэрхийлэх, тендер шалгаруулалтад шууд оролцох болон тухайн гэрээний хувьд туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвших, мөн (ii) одоо хэрэгжиж буй гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүрээнд орж ажиллахыг хориглох нөхцөл хамаарах ба мөн үүгээр үл хязгаарлагдана.

² Туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвшсэн этгээд (тухайн тендерийн баримт бичгийн төрлөөс хамааран ялгаатай нэрлэдэг) гэдэгт (i) тендерт оролцогчийн хувьд урьдчилсан сонголт эсхүл тендер шалгаруулалтад оролцоход нь шаардагдах чадварын шаардлагыг хангахад дэмжлэг болох чухал ач холбогдол бүхий онцгой туршлагатай, ноу хауг эзэмшсэн этгээд байх; эсхүл (ii) зээлдэгчийн томилсон этгээд байна.

³ Энд заасан хяналт шалгалт нь мөрдөн байцаах (жишээ нь шүүхийн) шинж чанартай байна. Эдгээрт залилан мэхлэх ба авлигын үйлдлийг тогтоохын тулд зохих механизмуудаар дамжуулан мөрдөн байцаалт/аудитын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Банкнаас хийж байгаа эсвэл Банкны томилсон төлөөлөгчөөр хийлгэж байгаа тусгай ажиллагаа орно. Үүнд дараах үйл ажиллагаа багтах бөгөөд мөн эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Тухайлбал: Хуулийн этгээд, хувь хүний санхүүгийн бүртгэл тооцоо, холбогдох мэдээллийг авч шалгах, шаардлагатай бол тэдгээрийн хуулбарыг хийх; мөрдөн байцаалт/аудитад холбоотой хэмээн тооцогдож буй бусад бичиг баримт, дата мэдээлэл (цаасан болон цахим хувилбараар), ажилтнууд болон бусад холбогдох хүмүүсээс ярилцлага авах; бодит мөрдөн байцаалтыг хийх, хэрэг болсон газарт очин биечлэн үзлэг хийх, мэдээллийг баталгаажуулах гуравдагч талын туслалцааг авах зэрэг болно.

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

1. Бид, Видео архивын материал бэлтгэх CS08-ыг _____ (тендерийн үнийг тоогоор болон үсгээр) төгрөгөөр гэрээний нөхцөл болзолын дагуу гүйцэтгэхээр санал болгож байна. Үнийг гэрээний хэрэгжилтийн хугацаанд тохируулахгүй. Үнэд дараах татвараас бусад татварыг тооцож оруулсан: захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ.
2. Гэрээний төлбөрийг төгрөгөөр хийх болон Үнийн саналын үнэ нь Гэрээний хэрэгжилтийн хугацаанд тогтмол байхыг бид хүлээн зөвшөөрч байна. Үнийн хуваарьд заасан бүх нэр зүйлсийг бүх тоо ширхгээр бэлтгэх, хэвлэх, эцсийн цэгт тээвэрлэн хүргэх, холбогдох даатгал хийлгэх, эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгөх, хариуцлагыг биелүүлэх, бусад зардал, ашиг зэргийг Үнийн саналд тооцож шингээсэн.

Үнийн хуваарь

Үйл ажиллагаа	Үнэ (₮)
Видео архивын материал бэлтгэх
Нөхцөлт үнийн дүн (олон нийтэд хүргэх - Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Youtube, Facebook, бусад цахим хуудас)	51,000,000
Үнийн саналын нийт дүн	

Энэ 51,000,000 төгрөгийн нөхцөлт үнийн дүнг тендерт оролцогч нь өөрчлөхгүй өөрийн үнийн саналд тусгана.

3. Бид, гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш дор дурдсан нийлүүлэлтийн хуваарьт багтаан “ажил, үйлчилгээний тодорхойлолт”-ыг гүйцэтгэхээр санал болгож байна.

Гэрээнд гарын үсэг зурснаас хойш __ сарын дотор Видео архивын материалыг бэлтгэж, дуусгана.

Видеоны нэр, үнийн дүн	Үйлдвэрлэсэн он	Үргэлжлэх хугацаа - мин	Хэл	Захиалагч	CD-ээр хавсаргасан эсэх, линк, гэрээ, актыг хавсаргасан эсэх тайлбар

Албан тушаал	Овог, нэр, төрсөн он, мэргэжил	Анкетыг хавсаргасан эсэх
Видео архивын материал бэлтгэх ажлын дарга / продюсер / найруулагч		

Видео архивын материалын агуулгын зохиолч		
Зураглаач / Эвлүүлэгч:		

4. Үнийн санал нь үнийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ___ хоногийн хугацаанд хүчинтэй.
5. [Аль нэг хувилбарыг сонгох, үнийн хөнгөлөлт санал болгох бол тооцох аргачлал, хувь, дүнг тодорхой бичих, Бид үнийн хөнгөлөлт санал болгоогүй. Бид дараах үнийн хөнгөлөлт санал болгож байна.]
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно. Таны хамгийн бага үнэтэй болон аль ч үнийн саналыг заавал шалгаруулах үүрэггүй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.
7. Тус компани нь энэ сонгон шалгаруулалтын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зохиосон хувь хүн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд [мөн, биш – аль нэгийг сонгох] болно.
8. Бид гэрээний маягт, гэрээний нөхцөл болзолын нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
9. Бид болон гэрээний гүйцэтгэлд оролцох аливаа туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь Дэлхийн банкны группийн гишүүн эсвэл Дэлхийн банк болон бусад хөгжлийн банкуудын хооронд байгуулсан Тендер шалгаруулалтын шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу түр хугацаагаар түдгэлзүүлсэн эсвэл хар жагсаалтад орсон байгууллага болон хувь хүнтэй холбоогүй бөгөөд удирдлагад нь ажилладаггүй болно. Түүнчлэн Захиалагчийн орны хууль тогтоомж эсвэл НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу эсвэл албан журамд үл нийцсэн биш болно.
10. Бид Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны 3.21-3.25, 3.32 заалтуудын дагуу Захиалагчтай ямарваа нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгийг мэдэгдэж байгаа бөгөөд энэхүү тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг, материалыг Дэлхийн банкнаас томилон бие даасан аудитораар хянуулахад татгалзах зүйлгүй болно.
11. Манай компани нь Дэлхийн банкны хоригийн жагсаалтад ороогүй.
12. Маягт № 1, 2, 3-ыг бэлтгэж хавсаргав.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг, хаяг, утасны дугаар, имэйл хаяг]:*

**МАЯГТ № 1 - ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл бараа хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг, хаяг, утасны дугаар, имэйл хаяг]:*

МАЯГТ № 2 - ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Тендерт оролцогч, нийлүүлэгчид өгөх заавар: энэ маягтыг бөглөөд энэ зааврыг устгана уу

Энэ маягтыг бүх тендерт оролцогч бөглөж тендерийн хамт ирүүлнэ.

Шалгарсан тендерт оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох мэдээгдэл аваад энэ маягтыг шинэчилж өгнө. Түншлэлийн хувьд, гишүүн бүрээр энэ маягтыг бөглөнө. Энэ маягтад дурдах мэдээлэл нь тендер ирүүлэх үеийн бодит мэдээллийг агуулна.

Энэ маягтын хуулийн этгээдийн өмчлөгч гэдэгт дараах нөхцөлийн нэг буюу түүнээс олныг нь хангасан эцсийн хувь хүнийг хэлнэ:

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

Тендер шалгаруулалтын нэр:

Тендер шалгаруулалтын №:

Үнийн саналын урилгын дагуу өмчлөгчийн талаарх мэдээллийг доорх байдлаар хүргүүлж байна: *[аль нэг хувилбарыг сонгоно уу]*

Бидний өмчлөлийн мэдээлэл нь дараах болно.

Хувилбар 1

Өмчлөгчийн нэр	<i>Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй (Тийм / Үгүй)</i>
<i>[ургийн овог, овог, нэрийг бүтнээр нь бичих, иргэншил, оршин суугаа улсыг бичих</i>			

Хувилбар 2

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгч байхгүй болохыг бид мэдэгдэж байна:

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

Хувилбар 3

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгчийг тогтоон тодорхойлох боломжгүй болохыг бид мэдэгдэж байна: *[энэ хувилбарыг сонгосон бол, яагаад тодорхойлох боломжгүй талаарх тайлбарыг энд бичнэ]*

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

Тендерт оролцогчийн нэр: *[*оноосон нэрийг бүтнээр бичнэ*]

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Огноо:

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны ___ сарын ___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Захиалагч нь CS08 дугаартай Видео архивын материал бэлтгэх, нийлүүлэх ажлыг (цаашид “бараа” гэх) _____ [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Гэрээний үнэд дараах татвараас бусад татварыг тооцож оруулсан: захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ. Гэрээний үнэд “нөхцөлт үнийн дүн”-гийн 51,000,000 төгрөг шингэсэн болно.

2. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” Дэлхийн банкны төслийн хөрөнгөөр 100 хувь санхүүжүүлнэ.

3. Захиалагч гэрээний үнийг Нийлүүлэгчийн ___ банкны ___ тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь Видео архивын материалыг ___ оны ___ дугаар сарын ___-ны өдрийн дотор хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Үнийн санал
Гэрээний нөхцөл болзол
Гэрээний нэмэлт өөрчлөлт (гарсан бол)

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

Дээрхийг гэрчилж талууд нь дээр дурдсан он, сар, өдрөөр энэхүү Гэрээг Монгол Улсын хуулийн дагуу байгуулав

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА
[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ТАМГА
[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

МАЯГТ № 3 - ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛЗОЛ БҮЛЭГ

Гэрээний нэр:	Видео архивын материал бэлтгэх
Гэрээний дугаар:	CS08
Төслийн нэр:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл

1. Ажил үйлчилгээний тодорхойлололт: хавсаргав.
2. Гэрээний үнэ тогтмол байх: Үнийн саналын маягтад заасаны үнэ нь гэрээний хэрэжилтийн хугацаанд үнийн тохируулгын нөхцөлд хамаарахгүй, тогтмол байна.
3. Хэрэглэх хууль: Монгол Улсын хууль.
4. Маргаан шийдвэрлэх: Энэхүү Гэрээнээс үүссэн, эсвэл түүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд аль болох хоорондоо харилцах замаар шийдэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол, маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
5. Төлбөр: “Нөхцөлт үнийн дүн”-г хассан Гэрээний үнийг захиалагч нь дараах хуваарийн дагуу төлнө:
 - 5.1. Захиалагчийн баталсан зохиол/найруулгыг үндэслэн, 21 хоногийн дотор 30%-ийг;
 - 5.2. Захиалагчийн баталсан видео архивын материалын төслийг үндэслэн 21 хоногийн дотор 30%-ийг;
 - 5.3. Захиалагчийн баталсан эцсийн видео архивын материалыг үндэслэн 21 хоногийн дотор 30%-ийг;
 - 5.4. Захиалагчийн баталсан видео архивын материалыг олон нийтэд хүргэсэн тайланг үндэслэн 21 хоногийн дотор 10%-ийг тус тус төлнө.

Нөхцөлт үнийн дүнг тухай бүр батлах Захиалагчийн хуваарийн дагуу нөхцөлт үнийн дүнг төлнө.
6. Гэрээний гүйцэтгэлийн хяналт: Захиалагч нь Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргыг, эсхүл түүний томилсон этгээдийг энэ гэрээний Захиалагчийн зохицуулагчаар томилж байна. Зохицуулагч нь Гэрээний хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг зохицуулах, тайлан, төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах, батлах эрх, үүрэгтэй болно.
7. Хяналт шалгалт, аудит: Нийлүүлэгч нь Дэлхийн банк, Дэлхийн банкнаас томилогдсон этгээдэд үнийн санал бэлтгэх, ирүүлэх явц болон Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой нийлүүлэгчийн бүх данс, бүртгэлийг шалгах, тэдгээрт аудит хийлгэхийг зөвшөөрнө.

8. Нууцлал: Нийлүүлэгч нь Гэрээний болон Гэрээ дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд Ажил үйлчилгээнд холбогдох нууцын зэрэглэлтэй болон оюуны өмчийн шинжтэй мэдээлэл, Захиалагчийн үйл ажиллагааг Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрснөөс бусад тохиолдолд бусдад задлахгүй.
9. Өмчлөл: Гэрээний дагуу Нийлүүлэгчийн Захиалагчид зориулан бэлтгэсэн тайлан, судалгаа, програм хангамж, видео архивын материал болон бусад зүйл нь Захиалагчийн өмч болно. Нийлүүлэгч нь эдгээр баримт бичиг, программ хангамжийн хувийг өөр дээрээ хадгалж болно.
10. Захиалагчийн хууль ёсны эрх ашиг: Нийлүүлэгч нь гэрээ болон Ажил үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн нийлүүлэгчийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална. Гуравдагч этгээд хохирсон хэмээн Захиалагчид гомдлын шаардлага гаргасан ба энэ нь Нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас гарсан бол, Нийлүүлэгч нь уг гомдлын шаардлагыг хангана.
11. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал: Ийм нөхцөл байдал үүссэний улмаас Нийлүүлэгчийн хэрэгжүүлж чадаагүй үүргийн гүйцэтгэлд алданги оногдуулахгүй, түүний улмаас нийлүүлэгчийн гэрээг цуцлахгүй.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт Нийлүүлэгчийн хяналтаас гадуур, урьдчилан тооцох боломжгүй, гэхдээ Нийлүүлэгчийн анхаарал халамжгүй байдлаас үүссэгүй нөхцөл байдлыг ойлгоно. Энэ нөхцөл байдалд дараах орж болно: дайн, иргэний бослого, гал түймэр, үер, цар тахал, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Нийлүүлэгч нь гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна

12. Гэрээг цуцлах: Энэ зүйлийн а-г заалтад дурдсан нөхцөл байдлын аль нэг тохиолдвол Захиалагч нь доод тал нь ажлын 10 хоногийн хугацаатай мэдэгдэл бичгээр Зөвлөхөд өгснөөр Гэрээг цуцалж болно:

12.1. Нийлүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын долоон (7) хоногийн дотор, эсхүл захиалагчийн бичгээр сунгасан хугацаанд багтан доголдлыг арилган гэрээнд нийцүүлээгүй бол;

12.2. Нийлүүлэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон бол;

12.3. Захиалагчийн эсхүл Дэлхийн банкны үзэж буйгаар Нийлүүлэгч нь гэрээнд өрсөлдөх, гэрээг хэрэгжүүлэхдээ /Банкны тухайн үед баримталж буй баримт бичиг заасан тайлбараар/ авлига, хээл хахууль, хууран мэхлэх, үгсэн хуйвалдах, заналхийлэх, саад тотгор учруулах үйл ажиллагаанд холбогдсон бол;

12.4. Захиалагч өөрийн шаардлагын, эсвэл ямар ч өөр шалтгааны улмаас гэрээг цуцлахыг шийдвэрлэсэн бол;

12.5. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсээд 90 хоног үргэлжилвэл, энэ нь гэрээг цуцлах үндэслэл болно.

13. Авлига, залилан мэхлэх үйл ажиллагаа: Дэлхийн банк нь энэ Гэрээний Хуваарь № А-д заасан авлига, залилан мэхлэх үйл ажиллагааны талаарх бодлогыг чанд мөрдөхийг шаардаана.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг, хаяг, утасны дугаар, имэйл хаяг]:*

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. ОРШИЛ

2019 оны арванхоёрдугаар сарын сүүлчээр БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод шинэ төрлийн корона вирусын халдварын дэгдэлт илэрсэн. Халдвар дэлхий даяар тархаж, 2020 оны 3-р сард Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага үүнийг цар тахал гэж зарлаж, КОВИД-19 гэж нэрлэсэн. Энэ өвчин нь дэлхийн улс орнуудад маш хурдацтай тархаж, олон хүнийг хамарч, цар тахлын хэмжээнд хүрсэн. Монгол Улсад 1 сая гаруй хүн COVID-19 вирусын халдвар авч, нас баралтын түвшин дөнгөж 0.18 хувьтай байгаа нь дэлхийн дунджаас хамаагүй доогуур үзүүлэлт юм.

Тухайн үед Монгол Улс корона вирустэй тэмцэх шуурхай стратеги боловсруулж, урьдчилан сэргийлэх ажилд онцгой анхаарч, ард иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, ДЭМБ-ын зөвлөмжийг цаг алдалгүй мөрдөж ирсэн. Монгол Улс тахал өвчинтэй тэмцэхэд эрүүл мэнд, төрийн албан хаагчид, онцгой байдал, цагдаагийн бие бүрэлдэхүүнээ дайчилж, ДЭМБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ, Япон улс зэрэг олон улсын байгууллагуудын асар их дэмжлэгийн ачаар тахлыг хамгийн бага хохиролтой даван туулж чадсан. Зөвхөн улс дотор төдийгүй улс хоорондын нийт хөл хорионы үед нөхцөл байдал хүнд байсан бөгөөд нийлүүлэлтийн бүх сүлжээ логистик тасалдсан.

2. ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Нийлүүлэгч нь 3 төрлийн видео архивын материалыг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэн, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3. ЗОРИЛГО / ҮР ДҮН

Энэхүү Гэрээний зорилго нь COVID-19 тахал өвчнийг даван туулахын тулд идэвх зүтгэл, нэр их хөдөлмөр, хүч чармайлт гаргаж ажилласан салбар, албан байгууллага бүрийг хамарсан, тэдгээрийн амжилт, хөдөлмөр зүтгэл, зохион байгуулалтын болон эмчилгээний шинэ арга барил, сургамж, төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа зэргийг харуулсан 60 минутын урттай видео архивын материал бэлтгэж, түгээн дэлгэрүүлэхэд оршино. Аюултай өвчин, гамшиг тохиолдоход өөрийгөө, олон нийт, ард иргэдээ хэрхэн хамгаалах, хэрхэн зохион байгуулалтад орох, хохирол багатай давж гарах арга барилыг олон нийтэд мөн харуулах болно.

4. АЖЛЫН ХҮРЭЭ

Нийлүүлэгчийн үүрэг хариуцлагад дараах ажлыг хамааруулна: төлөвлөлт, архивын материалын үзэл баримтлал, зохиомж, сэдвийн өрнөл, зохиол, найруулга, төрөл бүрийн байгууллага, хувь хүн, мэдээллийн хэрэгсэлд хандан архивын материал цуглуулах, зураг авалт, өнгө оруулалт, дуу оруулалт, монтаж, хөгжим зэрэг **60 минут** видео архивын материалыг, түүний **20 минут** богиносгосон хувилбарыг үйлдвэрлэх бүхий л шаардлагатай үйл ажиллагаа. Дохионы хэл, англи хэл дээрх subtitle тай байх. Энэ дохионы хэл, мөн subtitle ийг унтрааж болох option той байна. Нийлүүлэгч нь мөн “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн ололт амжилтын талаар **2-3 минутын** видео архивын материал бэлтгэнэ. Энэ видео нь мөн дохионы хэл, англи хэл дээрх subtitle тай байх. Энэ дохионы хэл, мөн subtitle ийг унтрааж болох option

той байна, эсхүл давхар dubbing файлыг өгнө. Баримтат видеонуудыг hard disk-энд DVD форматаар хуулж өгнө. Hard disk-ийг Нийлүүлэгч нь худалдан авч өгнө.

Нийлүүлэгч нь Эрүүл мэндийн яам, “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй нягт холбоотой ажиллана.

Зарим үйл ажиллагааг онцлон дурдахад:

1. Суурь судалгаа хийх, зураг авалтад оролцох байгууллага, хүмүүс, архивын материал авах байгууллага, хувь хүний жагсаалт гаргах - захиалагчаар батлуулах.
2. Цар тахлын үед хийгдсэн архивын бичлэг цуглуулах (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шадар сайдын ажлын алба, Эрүүл мэндийн яам, ДЭМБ, НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон, Хятад зэрэг зарим орны Элчин сайдын яамд ГХЯ, ОБЕГ, ХНХЯ, ЗТХЯ, бусад байгууллага, хүмүүс, төрөл бүрийн нээлттэй эх сурвалжууд).
3. Зохиол / найруулга бичих – захиалагчаар батлуулах.
4. Видео материал нь өнгөт байна, Нийлүүлэгчийн авсан видео материалын чанар хамгийн багадаа 4К нягтралтай.
5. Видео монтаж.
6. Аудио болон хөгжмийн дагалдалт - захиалагчтай зөвлөлдөх.
7. 3 төрлийн видео архивын материалыг гэрээ байгуулснаас хойш 45 хоногийн дотор хийж дуусгах – захиалагчаар батлуулах.
8. Төрийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан түгээх.
9. Үндэсний болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиалаар олон нийтэд түгээх, энэ талаар зардлын задаргаа төлөвлөгөө ирүүлж захиалагчаар батлуулах – энэ зардлыг гэрээний нөхцөлт үнийн дүнгээс санхүүжүүлнэ, санхүүжилтийн төлөвлөгөө, задаргааг захиалагч урьдчилан зөвшөөрнө.